



## Шинжээчийн тайлан

(Магистрын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл)

**Байгууллагын нэр:** Соёл урлагийн их сургуулийн Соёлын сургууль

**Хөтөлбөрийн нэр:** Соёл судлал

**Индекс:** 031401 магистр

### Шинжээчийн баг:

Ахлагч:	А.Энхбат	ШУТИС-ийн БУХС-ийн захирал, доктор
Гишүүд:	Т.Дорждавга	БМИҮЗ-ийн шинжээч, доктор, профессор
	Ц.Нямсүрэн	МУИС-ийн ШУС-ийн Философи, шашин судлалын тэнхимийн дэд профессор, доктор

## **Агуулга**

### **Товчилсон үгийн тайлбар**

#### **I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт**

#### **II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга**

#### **III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

Шалгуур 1: Хөтөлбөрийн зорилго, агуулга

Шалгуур 2: Хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт

Шалгуур 3: Суралцахуйн үнэлгээ, хөгжил

Шалгуур 4: Багшлах бүрэлдэхүүн

Шалгуур 5: Нөөц ба санхүүжилт

Шалгуур 6: Удирдлага ба мэдээллийн систем

Шалгуур 7: Чанарын баталгаажуулалт

#### **IV. Уулзалтад оролцогчдын нэрс**

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

#### **V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**

#### **VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр**

#### **VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

## I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

<b>Сургуулийн нэр /Монгол, Англи/</b>	Соёл Урлагийн Их Сургуулийн Соёлын сургууль	
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/</b>	Соёл судлал	
<b>Индекс</b>	031401 магистр	
<b>Шинжээчид</b>	А.Энхбат ШУТИС-ийн БУХС-ийн захирал, доктор Т.Дорждавга БМИУЗ-ийн шинжээч, доктор, профессор Ц.Нямсүрэн МУИС-ийн ШУС-ийн Философи, шашин судлалын тэнхимийн дэд профессор,	
<b>БМИУЗ-ийн Мэргэжилтэн</b>	Н.Түмэнжаргал	
<b>Төлөвлөгөө</b>	<b>Он сар өдөр</b>	<b>Хийгдсэн байх ажлууд</b> /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу
	2023-04-26	Шинжээчийн баг томилох
	2023-05-01	Шинжээчийн багийн уулзалт
	2023-05-11	ШУҮТ явуулах
	2023-05-15,16	Сургуульд ажиллах
	2023-05-24	ШҮТ ирүүлэх
	2023-05-25	Сургуульд ШҮТ хүргүүлэх
	2023-06-...	МЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэх
<b>Шалгуур шаардлага /журам/</b>	БМИУЗ-ийн Удирдах зөвлөлийн 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 06 тоот тогтоолоор баталсан “Магистрын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх шалгуур шаардлага”, Ажлын албаны захирлын 2023.04.26-ны өдрийн Шинжээчийн баг томилох тухай А/123 тоот тушаал	

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор 1990 онд Соёл урлагийн дээд сургууль (одоогийн Соёл Урлагийн Их Сургууль)-ийг байгуулсан. “Соёл судлал” мэргэжлийн магистрын хөтөлбөрөөр 1994 онд анхны элсэлт авч 1996 онд анхны төгсөлт хийсэн байна. Тус хөтөлбөрөөр нийт 54 хүн төгссөн бөгөөд одоо 12 магистр оюутан суралцаж байна. Соёлын бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх, соёл хоорондын харилцааг идэвхжүүлэх, өөрийн болон бусдын соёлыг хүндэтгэх, соёлын практик амьдралд шинжлэх ухааны үндэслэлтэй хандах үзэл ойлголт төлөвшүүлэхэд энэхүү хөтөлбөр ихээхэн үүрэг гүйцэтгэсэн.

### III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

#### Шалгуур 1. Хөтөлбөрийн зорилго, агуулга

Дээд боловсролын болон сургуулийн зорилго, мэргэжлийн салбарын судалгаа ба хөгжлийн бодлоготой уялдуулан оролцогч талуудын эрэлт хэрэгцээг тусган хөтөлбөрийн зорилго, агуулгыг шинэчлэн, хөтөлбөрийн чанарыг байнга сайжруулдаг байна

##### 1.1 Хөтөлбөрийн боловсруулалт

Дээд боловсролын хууль эрх зүй, магистрын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага, хэрэглэгч ба оролцогч талуудын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөтөлбөрийг иж бүрэн боловсруулж, хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор жил бүр хянан үнэлдэг байна. Магистрантын сургалт болон судалгаа, хөгжил, бүтээлч ажлуудын төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ, чанарын баталгаажуулалтын арга барил нь хувь хүний болон мэргэжлийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн чөлөөт сонголт бүхий олон хувилбартай хэрэгждэг байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Дүрэм журмын эмхэтгэл
- Соёл судлал мэргэжлийн магистрын иж бүрэн хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө
- Элсэлт, төгсөлттэй холбоотой баримт бичгүүд

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

- Олон жилийн туршлагатай.
- Соёл судлалын онол, түүхийн суурийг хөтөлбөрт сайн тусгаж өгсөн.
- Хөтөлбөр шинэчлэл хийгддэг. 2009, 2011, 2014, 2019 онуудад төлөвлөгөө, бүтэц, агуулгад өөрчлөлт хийсэн. Оролцогч талуудын санал тусдаг.
- Хөтөлбөрт үнэлгээ хийж, магистр оюутны судалгааны сэдэвт чөлөөт сонголт хийх бололцоог бий болгосон.
- Хөтөлбөрийг зөв тодорхойлсон. Хөтөлбөр хоорондын харьцуулалт сайн хийсэн.

**Анхаарах асуудал:** /Сул тал/

- Хөтөлбөр хэт ерөнхий

**Дүгнэлт:** Хөтөлбөрийн чанарын сайжруулалт байнга хийгддэг.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**Зөвлөмж:** /Анхаарах асуудалд чиглэсэн байна/

- Магистрын хөтөлбөрт шинэчлэл хийхдээ өөрсдийн хүний нөөц, судалгааны тэргүүлэх чиглэлд тулгуурлан мэргэшүүлэх

##### 1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн төгсгөлд магистрантын эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадал буюу суралцахуйн зорилтот үр дүнгээр хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон байна. Хөтөлбөрийн зорилго нь үндэсний болон глобал хөдөлмөрийн зах зээлийн шинэ эрэлт хэрэгцээ, сургуулийн зорилгод нийцсэн (өөрийн сургуулийн магистрын сургалтын онцлог, давуу байдлыг тусгасан) байна. Суралцахуйн зорилтот үр дүнг тодорхойлоход хэрэглэгч ба оролцогч талуудыг татан оролцуулж, тэдний эрэлт хэрэгцээ, шаардлагыг тусгасан байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Дүрэм журмын эмхэтгэл
- Соёл судлал мэргэжлийн магистрын иж бүрэн хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө

- Хичээлүүдийн төлөвлөгөө
- Элсэлт, төгсөлттэй холбоотой баримт бичгүүд
- Судалгаанууд

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

- Магистрын хөтөлбөрт чадвар, дадал, зорилгыг зөв гаргаж, Блумын таксономын үйлийн системчилсэн ангилалтай уялдуулан тодорхойлсон.
- Хөтөлбөр сургуулийн зорилгод нийцсэн. Онцлог, давуу талтай
- Оролцогч талуудыг татан оролцуулдаг.

**Анхаарах асуудал:** /Сул тал/

- Магистрын хөтөлбөрт дадлага хийх боломж харагдахгүй байна.

**Дүгнэлт:** Хөтөлбөрт өөрийн давуу тал, онцлог зэргээ хангалттай сайн тусгасан.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**Зөвлөмж:** /Анхаарах асуудалд чиглэсэн байна/

- Хамтын ажиллагаатай байгууллага олон байгаа давуу талаа ашиглан магистр оюутнуудыг дадлага хийлгэдэг байх
- 

### 1.3 Хөтөлбөрийн агуулга

Хөтөлбөрийн агуулга нь суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай суралцахад чиглэсэн байна. Хөтөлбөрийн агуулга нь мэргэжлийн ахисан түвшиний судалгааг хөгжүүлэхэд чиглэх ба онол практикийг зохистой хослуулан, логик дэс дараалалтай, давхардалгүй хэрэгжүүлэх сургалтын болон судалгааны төлөвлөгөөг боловсруулж, заавал болон сонгон суралцах агуулга, сургалтын хэлбэрийг зохистой тогтоож, мөрддөг байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Дүрэм журмын эмхэтгэл
- Соёл судлал мэргэжлийн магистрын иж бүрэн хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө
- Хичээлүүдийн агуулга, төлөвлөгөө

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

- Хөтөлбөрийн агуулга Соёл судлалын үндсэн ойлголттой бүрэн нийцсэн. Дэс дараалалтай, давхардалгүй. Суралцахуйн үр дүнтэй холбогдсон.

**Дүгнэлт:** Хөтөлбөр логик дэс дараалалтай, давхардалгүй.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

### 1.4 Хичээлийн хөтөлбөрүүд

Сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх хичээл бүрийн хөтөлбөрийг иж бүрэн боловсруулсан байна. Үүнд: тухайн хичээлийг судлах үндэслэл, урьдач нөхцөл, уялдаа холбоо, суралцахуйн зорилтот үр дүн, хичээлийн агуулга, багц цаг, магистрантын суралцахуйн ачаалал, үнэлгээний аргачлал зэргийг дэлгэрэнгүй багтаасан байна. Хичээлийн хөтөлбөрүүд нь суралцагчдын мэргэжлийн болон хөрвөх ур чадварыг хөгжүүлэхэд чиглэх ба тэдгээрийг суралцагчдад ил тод мэдээлдэг, шаардлагатай тохиолдолд гарын авлага

болгон хэвлэсэн байна. Магистрант нь хувь хүний хөгжлийн болон судалгааны ур чадвараа хөгжүүлэх боломжийг хичээлийн хөтөлбөрүүдэд тодорхой тусгасан байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Дүрэм журмын эмхэтгэл
- Соёл судлал мэргэжлийн магистрын иж бүрэн хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө
- Элсэгчийн гарын авлага
- Хөтөлбөрийн хороо, дэд хороо, Эрдмийн зөвлөлийн тушаал, шийдвэр
- Хичээлүүдийн хөтөлбөр, төлөвлөгөө
- Сурах бичгүүд, эрдэм шинжилгээний сэтгүүлүүд
- Багш нарын эрдэм шинжилгээний бүтээлүүд

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

- Хичээлийн өмнөх холбоо, хичээл хоорондын залгамж холбоо сайн.
- Шинэчлэл хийхдээ сонгон суралцах хичээлүүдийг нэмэгдүүлсэн. Өөрчлөлт хөтөлбөрт сайн хийгдсэн.
- Музейн чиглэлээр шинэ хөтөлбөр нээхээр төлөвлөж, бэлтгэж байгаа.
- Судлаачийн ёс зүйг олгох хичээл байна.
- Магистр оюутанд зориулан эрдэм шинжилгээний хурлыг хичээлийн жилд 2 удаа зохион байгуулдаг, шилдэг өгүүллийг үнэ төлбөргүй хэвлүүлдэг.
- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг тодорхойлохдоо ITUA загвар ашиглан боловсруулсан.

**Анхаарах асуудал:** /Сул тал/

- Музей, соёлын аялал жуулчлалын чиглэлээр мэргэших боломж бүрдүүлсэн. Гэхдээ эдгээр нь тусдаа бие даасан хөтөлбөр гэдгийг тооцож үзэх.

**Дүгнэлт:** Иж бүрэн сургалтын төлөвлөгөөтэй. Боловсруулалт сайн хийгдсэн.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**Зөвлөмж:** /Анхаарах асуудалд чиглэсэн байна/

- Сургуулийн давуу талыг ашиглан соёлын биет бус өв судлал чиглэлд илүү мэргэшүүлэх

### **1.5 Хөтөлбөрт тавих тусгай шаардлага**

Хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүн, агуулга нь тухайн хөтөлбөрийн хамаарах ерөнхий, төрөлжсөн, нарийвчилсан чиглэлээр Мэргэжлийн зөвлөлөөс тогтоосон тусгай шаардлагыг хангасан байхаас гадна үндэсний болон олон улсын сайн туршлагыг нутагшуулахыг эрмэлзэнэ.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Дүрэм журмын эмхэтгэл
- Соёл судлал мэргэжлийн магистрын иж бүрэн хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө
- Хөтөлбөрийн хороо, дэд хороо, Эрдмийн зөвлөлийн тушаал, шийдвэр

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

- Хөтөлбөрийн суралцахуйн судалгааны их сургууль руу чиглэсэн.
- Хичээлүүдийн нэрийг англи хэлээр орчуулж, олон улсад харьцуулах боломж олгосон.
- Хөтөлбөрийн шинэчлэл хийхдээ олон улсын ангилал, сургалтын дидактикт үндэслэсэн.
- СУИС-ийн 2012-2021, 2018-2024 оны мастер төлөвлөгөө, тэргүүлэх чиглэлд нийцсэн.
- Дэлхийн шилдэг их, дээд сургуулиудын ижил төстэй хөтөлбөрүүдтэй харьцуулсан. Дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулж ялгааг сайн гаргаж өгсөн.

**Дүгнэлт:** Хөтөлбөрт олон улсын сайн жишиг тусгасан.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**1-р шалгуурын талаарх шинжээчийн багийн үнэлгээ:** Бүрэн хангасан

### **Шалгуур 2. Хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт**

Магистрын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн орчинг бүрдүүлж, магистрантын суралцахуй ба судалгааны ажлыг дэмждэг байна.

#### **2.1 Элсэлт**

Элсэгчид тавих шаардлага нь магистрын хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүнд хүрэх боломжийг тооцсон, шударга, ил тод байна. Элсэгчийн мэргэжлийн болон судалгааны туршлага, ур чадвар, амжилтыг харгалзан тодорхой нөхцлөөр элсүүлэх боломжийг бүрдүүлэхээс гадна гадаад хэлний (TOFEL, IELTS) болон судалгааны чадавхыг үнэлэх олон улсын үнэлгээг тооцдог байна. Судалгааны сэдэв болон удирдагч багшийг сонгох, санхүүжилтийн хэлбэр, хэмжээг тогтоох журмууд нь тодорхой, ил тод байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Дүрэм журмын эмхэтгэл
- Магистрын гарын авлага
- Соёл судлал мэргэжлийн магистрын иж бүрэн хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө
- Элсэгчийн гарын авлага
- Элсэлтийн тушаал, холбогдох баримт бичгүүд

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

- Элсэгчид тавих шаардлага тодорхой, элсэлт ил тод байна.
- Элсэлтийн дүрэм, журмууд нээлттэй, цахим хуудаст байна.
- Өвөл, хавар элсэлт зохион байгуулдаг.

**Анхаарах асуудал:** /Сул тал/

- Элсэлт хэтэрхий олон, нийт 7 үе шаттай.
- Элсэгчийн тоог нэмэгдүүлэх

**Дүгнэлт:** Элсэлт ил тод, ойлгомжтой.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**Зөвлөмж:** /Анхаарах асуудалд чиглэсэн байна/

- Элсэлтийн маркетинг хийдэг болох.

## 2

Хөтөлбөрөөр суралцах магистрантын танхимд болон бие даан суралцах, судалгаа хийх ачаалал нь улирал бүрт жигд, зохистой хэрэгжиж хэт ихсэх буюу багасахаас сэргийлдэг байна. Магистрантын суралцах хугацаа хэвийн хэмжээнээс хэтрэхгүй байхад чиглэсэн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Дүрэм журмын эмхэтгэл
- Магистрын гарын авлага
- Соёл судлал мэргэжлийн магистрын иж бүрэн хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

- Магистр оюутан бие даан суралцах орчинг бүрдүүлсэн.
- Эчнээ суралцах боломжийг бүрдүүлсэн.
- Гадаад, дотоодын их дээд сургуулийн мэргэжлийн суурь хичээлийг дүйцүүлэх зохицуулалт хийсэн.

**Анхаарах асуудал:** /Сул тал/

- Хичээлийн 7 хоног 16 байна.

**Дүгнэлт:** Магистр оюутны ачаалал жигд байна.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**Зөвлөмж:** /Анхаарах асуудалд чиглэсэн байна/

- Хичээлийн 7 хоногийг багасгаж 15 болгох боломжийг судлах.
- Элсэлтийн маркетинг хийдэг болох.

### 2.3 Багшлахуй ба суралцахуйн арга зүй

Багшлахуй ба суралцахуйн арга зүй нь суралцагч төвтэй арга барилд тулгуурласан, магистрантыг суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай суралцахад нь дэмждэг байна. Үүний зэрэгцээ судлаачийн болон мэргэжлийн ёс зүй, арга барилыг дээдлэн хөгжүүлдэг байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Дүрэм журмын эмхэтгэл
- Магистрын гарын авлага
- Соёл судлал мэргэжлийн магистрын иж бүрэн хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө
- СУИС-ийн албаны баримт бичгүүд

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

- Хөтөлбөр ерөнхийгөөс нарийвчлах, гүнзгийрэн мэргэших эрэмбээр хичээлүүдийн дэс дарааллыг тогтоосон.
- Цахим хичээлийн агуулгыг Динамик платформ, Ding Talk, Фейсбүүк ашиглан хүргэдэг.
- Хичээлүүдийн заах арга зүйн жагсаалт боловсруулсан.



**Дүгнэлт:** Сурагч төвтэй арга зүйтэй. Судлаачийн ёс зүйг эзэмшүүлдэг.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

## 2.4 Судалгааны ажил

Магистрант болон удирдагчийн үйл ажиллагааг харилцан уялдаатай тодорхойлсон ил тод журмаар сургалтын болон ганцаарчилсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу магистрантын судалгааны ажлын гүйцэтгэлийг хянан идэвхжүүлдэг байна. Удирдагч багш нар нь судалгааны ажлыг удирдах ур чадвараа байнга хөгжүүлж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлдэг байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Дүрэм журмын эмхэтгэл
- Магистрын гарын авлага
- Соёл судлал мэргэжлийн магистрын иж бүрэн хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

- Мэргэжлийн тэнхим, эрдэмтэн нарийн бичгийн дарга, ахисан түвшний сургалтын алба хамтран магистрын сургалтын төлөвлөгөө, хичээл бүрийн агуулгыг боловсруулж, гүйцэтгэлийг хянадаг.
- Магистр оюутны судалгааны ажлын үр дүнг эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлдэг. Нийт 228 өгүүлэл олны хүртээл болгосон.

**Дүгнэлт:** Судалгааны ажлыг дэмждэг. Магистр оюутан сэтгүүлд өгүүлэл хэвлүүлдэг.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

## 2.5 Бүтээлч ажил

Магистрант нь шинжлэх ухааны арга хэмжээ, бага хурал, мэргэжлийн хэлэлцүүлэг зэрэг шинжлэх ухааны болон мэргэжлийн арга хэмжээ, үйл ажиллагаанд оролцох, судалгааны бүтээлээ хэвлүүлдэг байна. Магистрантын бүтээлч ажлыг дэмжин урамшуулах, үнэлэх, баталгаажуулах тогтолцоотой байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Дүрэм журмын эмхэтгэл
- Магистрын гарын авлага
- Соёл судлал мэргэжлийн магистрын иж бүрэн хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө
- Эрдэм шинжилгээний сэтгүүлүүд

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

- Ахисан түвшний оюутны эрдэм шинжилгээний хурлыг “Өв соёл” сэдвийн хүрээнд жилд 2 удаа зохион байгуулдаг.

- Магистр оюутны судалгааны ажлын үр дүнг төлөвлөгөөт семинар, их семинараар хэлэлцдэг.
- Магистр оюутныг хөдөлмөр эрхлүүлэх, туслахаар ажиллуулах журамтай.

**Анхаарах асуудал:** /Сул тал/

- Магистр оюутны оролцоотой төслийн тоо бага байна.

**Дүгнэлт:** Бүтээлч ажлыг дэмжих, хийх эрх зүйн орчинг бүрдүүлсэн.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**Зөвлөмж:** /Анхаарах асуудалд чиглэсэн байна/

- Магистр оюутны оролцоотой төслийн тоог нэмэх.

**2-р шалгуурын талаарх шинжээчийн багийн үнэлгээ: Бүрэн хангасан**

**Шалгуур 3. Магистрантын суралцахуйн үнэлгээ, хөгжил**

Хөтөлбөрөөр суралцагч нь суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай хүрэхэд чиглэсэн ил тод, шударга үнэлгээний системтэй байх ба амжилттай суралцах, хөгжиж төлөвшихөд нь зөвлөн тусалдаг байна.

**3.1 Суралцахуйн үнэлгээ, шалгалт**

Хөтөлбөрийн явцад үнэлгээний олон төрөл хэлбэрийг ашиглан суралцагчийн суралцахуйн зорилтот үр дүн (мэдлэг, чадвар, дадал)-гийн гүйцэтгэлийг үнэлэх тогтолцоотой байна. Үнэлгээний журам, шалгуур нь сургалт, судалгаа, соён гэгээрүүлэх ажлыг бүхэлд нь хамарсан байх ба суралцагчийн амжилтыг шударга ил тод үнэлж, сайжруулдаг байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Дүрэм журмын эмхэтгэл
- Магистрын гарын авлага
- Соёл судлал мэргэжлийн магистрын иж бүрэн хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө
- Багшийн журнал, оюутны вэб хуудас

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

- Магистр оюутныг хичээлийн төгсгөлд дүгнэхдээ 30 онооны шалгалтаас илүү судалгаа давамгайлсан кейс, бие даалтын ажилд илүү ач холбогдол өгсөн байна.
- Магистр оюутны үнэлгээнд гадаад хэлний шаардлага өндөр тавьсан.

**Дүгнэлт:** Дүгнэх арга зүй ил тод, ойлгомжтой.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**3.2 Суралцагчийн хөгжил, суралцахуйн хүрсэн үр дүнг хүлээн зөвшөөрөх**

Хөтөлбөрөөс гадуур суралцагчийн бие даан эзэмшсэн болон өөр сургууль, хөтөлбөрөөс суралцсан суралцахуйн үр дүнг хүлээн зөвшөөрч, багц цагийг дүйцүүлэн тооцдог байна. Түүнчлэн суралцагчийн mobility-г дэмжсэн /багц цагийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох,

багц цагаас чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нийцүүлдэг байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Дүрэм журмын эмхэтгэл
- Магистрын гарын авлага
- Соёл судлал мэргэжлийн магистрын иж бүрэн хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

- Дүйцүүлэлтийн зохицуулалт сайн хийгдсэн.

**Дүгнэлт:** Дүйцүүлэлтийн зохицуулалт хангалттай сайн.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

### 3.3 Магистрантыг дэмжих, зөвлөх үйлчилгээ

Суралцагчдыг амжилттай суралцах, хөгжиж төлөвшихөд нь дэмжих, зөвлөх үйлчилгээг системтэйгээр үзүүлдэг байна. Дэмжих, зөвлөх үйлчилгээ нь суралцагч /гадаад, шилжин ирсэн, ажил эрхэлдэг ба эрхэлдэггүй, боловсролын тусгай хэрэгцээтэй гэх мэт/-ийн хэрэгцээ, шаардлагаас үүдэх суралцахуйн орчин, нийгэм, сэтгэл зүйн асуудлыг шийдэхэд тусалж, сэтгэл ханамжийг дээшлүүлдэг байна. Магистрантын санал хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үйл явцыг тэдэнд нээлттэй мэдээлж, албан ёсны гомдлыг бүртгэж баримтжуулан, шийдвэрлэдэг байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Дүрэм журмын эмхэтгэл
- Магистрын гарын авлага
- Соёл судлал мэргэжлийн магистрын иж бүрэн хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

- АТСА-ны мэргэжилтэнтэй.
- Гадаад суралцагчдыг хариуцсан мэргэжилтэнтэй.
- Ахисан түвшний оюутнуудад зориулсан номын сан, эрдэм шинжилгээний номын сантай.

**Анхаарах асуудал:** /Сул тал/

- Тусгай хэрэгцээт оюутны орчин сул бүрдсэн.
- Сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авдаг болох.
- 

**Дүгнэлт:** Магистр оюутныг дэмжих эрх зүйн орчинтой. Нөхцөл бололцоог хангасан.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**Зөвлөмж:** /Анхаарах асуудалд чиглэсэн байна/

- Тусгай хэрэгцээт оюутны орчин бүрдүүлэх.

- Сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авдаг болох.

### 3.4 Судалгааны санхүүжилт

Сургуулийн судалгааны бодлого, хөтөлбөрийн зорилгод нийцүүлэн, магистрантын судалгааны ажлыг санхүүжүүлэх, санхүүжилтийг хянах, гүйцэтгэлийг үнэлэх ил тод бодлого, журмыг хэрэгжүүлж, жил бүр ил тод тайлагнадаг байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Дүрэм журмын эмхэтгэл
- Магистрын гарын авлага
- Соёл судлал мэргэжлийн магистрын иж бүрэн хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө
- Захирлын тушаалууд

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

- Магистр оюутныг судалгааны болон захиргааны туслахаар ажиллуулах эрх зүйн орчинг бүрдүүлсэн.
- Төсөл, орлоготой оюутан хөтөлбөртэй.

**Анхаарах асуудал:** /Сул тал/

- Магистр оюутныг төсөл, судалгааны цалинтай ажилд хамруулах ажлыг эрчимжүүлэх

**Дүгнэлт:** Судалгааны санхүүжилт олгох эрх зүйн орчинтой.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

### 3.5 Тэтгэлэг, тэтгэмж

Магистрантын сургалтыг санхүүжүүлэх эх үүсвэр, тэтгэлэг, тэтгэмж олгох нөхцөл, болзлыг тодорхой заасан дүрэм журмыг хэрэгжүүлж, үр дүнг жил бүр хянан үнэлдэг байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Дүрэм журмын эмхэтгэл
- Магистрын гарын авлага
- Соёл судлал мэргэжлийн магистрын иж бүрэн хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө
- Захирлын тушаалууд

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

- Шилдэг судлаач оюутанд тэтгэлэг олгодог.

**Анхаарах асуудал:** /Сул тал/

- Магистр оюутнууд тэтгэлэг, тэтгэмжинд бага хамрагдсан.

**Дүгнэлт:** Тэтгэлэг, тэтгэмжийн эрх зүйн орчин бүрдсэн.

## **Үнэлгээ: Бүрэн хангасан**

**Зөвлөмж:** /Анхаарах асуудалд чиглэсэн байна/

- Магистр оюутнуудыг цаашид тэтгэлэг, тэтгэмжинд түлхүү хамруулах.

### **3.6 Судалгааны баг, хамтын ажиллагаа**

Хөтөлбөрийн түвшинд үндэсний болон олон улсын, төрийн болон хувийн байгууллага, дээд боловсролын сургалтын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх гэрээтэй, дотоод болон гаднын судалгааны нэгж болон байгууллагуудтай холбоо тогтоож, түншилдэг байна. Багш, магистрантууд судалгааны багт оролцдог байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Дүрэм журмын эмхэтгэл
- Магистрын гарын авлага
- Соёл судлал мэргэжлийн магистрын иж бүрэн хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө
- Гэрээ, санамж бичгүүд
- Ахисан түвшний сургалтын хөтөлбөрийн танилцуулга

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

- Судалгааны профессорын багуудтай.
- СУИС-ийн судалгааны тэргүүлэх чиглэлд хийсэн шинжилгээ (2014-2020), Соёл урлагийн их сургуулийн магистр, докторын судалгааны бүтээлийн ном зүй (1994-2020) гаргасан.
- Судалгааны тэргүүлэх чиглэлийн үндэслэл, агуулга мөн чанар зэргийг тодорхойлсон.

**Дүгнэлт:** Судалгааны профессорын багуудтай. Судалгааны орчинг бүрдүүлсэн.

## **Үнэлгээ: Бүрэн хангасан**

### **3.7 Магистрын ажил хамгаалалт**

Магистрын ажил хамгаалах зөвшөөрөл олгох (шинэ мэдлэгийг бий болгох, үр дүнг ашиглах, багшлахуйн үнэлгээ, шилжилт хөдөлгөөн гэх мэт) тодорхой шалгуурууд нь магистрант, удирдагч нарт ойлгомжтой байна. Магистрын ажил хамгаалалтыг зохион байгуулах дүрэм (хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүн, гишүүдийн чиг үүрэг, хурлын дэг, танилцуулга хийх г.м.) магистрант, удирдагч нарт тодорхой, шударга, ил тод байдлаар хэрэгждэг байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Дүрэм журмын эмхэтгэл
- Магистрын гарын авлага
- Соёл судлал мэргэжлийн магистрын иж бүрэн хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө
- Захирлын тушаалууд

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

- Магистрын ажил хамгаалах дүрэм, журам ойлгомжтой, энгийн, хамгаалах шат дараалал тодорхой байна. Дүрэм, журам нээлттэй, вэб хуудаст байршсан.
- Магистрын ажил хамгаалах хуваарь тодорхой.

**Дүгнэлт:** Магистрын ажлын хамгаалалт энгийн ойлгомжтой эрх зүйн орчинтой. Дүрэм, журам нь нээлттэй.

**Үнэлгээ: Бүрэн хангасан**

### 3.8 Төгсөлтийн баримт бичиг

Төгсөгчид суралцсан хөтөлбөрийн хичээл тус бүрээр мэдлэг, ур чадвар, дадлын түвшинг жагсаасан хавсралт (англи хэл дээр) бүхий диплом, баримт бичиг олгох үйл явцыг холбогдох журмын хүрээнд хэрэгжүүлдэг байна. Төгсөгчид олгох баримт бичгүүд нь тухайн оюутны чадамжийн тухай мэдээлэл болон хөтөлбөрийн тодорхойлолт, суралцахуйн үр дүн, агуулга, түвшин түүнчлэн боловсрол, мэргэшлийн зэрэгтэй холбоотой мэдээллүүдийг багтаасан байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Дүрэм журмын эмхэтгэл
- Магистрын гарын авлага
- Соёл судлал мэргэжлийн магистрын иж бүрэн хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө
- Захирлын тушаалууд
- Төгсөлтийн баримт бичгүүд

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

- Төгсөлтийн баримт бичиг Монгол Улсын болон олон улсын жишигт нийцсэн.

**Дүгнэлт:** Төгсөлтийн баримт бичиг олгох явц журмын хүрээнд хэрэгждэг.

**Үнэлгээ: Бүрэн хангасан**

## 3-р шалгуурын талаарх шинжээчийн багийн үнэлгээ: Бүрэн хангасан

### Шалгуур 4. Багшлах бүрэлдэхүүн

Магистрын хөтөлбөрийн онцлогоос хамааран шинжлэх ухааны салбар ба суралцагчийн тоонд дүйцэх, хангалттай хүрэлцээтэй багшлах бүрэлдэхүүнтэй байна.

#### 4.1 Багшийн нөөц

Тухайн хөтөлбөрийн мэргэжлийн чиглэл, боловсролын зэргийн түвшинд тохирсон боловсролын зэрэг, эрдмийн цолтой, багшлах өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багш, судлаачийн нөөцтэй байна. Багш, докторантын тооны харьцааг зохистой тогтоож, мөрддөг байна. Хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор үндэсний болон олон улсын тэргүүлэх судлаач, эрдэмтдийг хөтөлбөрт урьж ажиллуулдаг байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Хөтөлбөрт доктор /PhD/ зэрэгтэй 9 багш /2 магистр багш хавсран тусалдаг.
- Хөтөлбөрт үндэсний тэргүүлэх судлаач, эрдэмтдийг урьж ажиллуулдаг.

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

- Өндөр мэргэжлийн профессор багш нараар суралцагчдын төгсөлтийн ажлыг голчлон удирдуулдаг.
- Сэдвийн хувьд мэргэжлийн болон эрхэлсэн ажлын чиглэлд бүрэн нийцэж байна.

**Дүгнэлт:** Багшлах нөөц хангалттай.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**Зөвлөмж:** /Анхаарах асуудалд чиглэсэн байна/

- Гадаадын байгууллага, эрдэмтэдтэй хамтарч төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн баримтууд тайланд хангалттай байна. Тиймээс цахимаар тэднийг урьж тодорхой хугацаанд алсын зайнаас хичээл заалгах бололцоотой юм.

#### **4.2 Багшлахуйн үнэлгээ**

Багшлахуйн үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, үнэлгээний үйл явцыг тодорхой журамлан, хөтөлбөрийн зорилго, зорилтуудад нийцүүлэн багшийн ур чадварыг шударга, бодитой, системтэй, тогтмол үнэлж, үнэлгээний үр дүнг цаг тухайд нь танилцуулдаг байна. Чадахуйд суурилсан үнэлгээний тогтолцоо нь багшийн байнгын хөгжлийг дэмждэг байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Дүрэм, журмын эмхэтгэл
- СУИС-ийн захирлын тушаалууд
- СУИС-ийн дэд профессор, профессор цол олгох журам

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

- Багш нараас Ш.Эрдэнэцэцэг Алтангадас одон, Ч.Мөнхжаргал СУИС-ийн “Оны шилдэг судлаач багш”, Д.Мандах СУИС-ийн “Оны шилдэг сурган хүмүүжүүлэгч багш”, Ж.Эрхэмтөгс Шинжлэх ухааны тэргүүний ажилтан, Б.Мөнхбадрал Захирлын нэрэмжит шагнал, шилдэг зөвлөх багш, шилдэг судлаач багш, М.Ганжаргал БСШУЯ-ны Жуух бичиг, Э.Энхсайхан МЗХ-ны Тэргүүний багш тэмдэг, Соёлын сургуулийн Шилдэг залуу багш зэрэг цол, шагналууд хүртжээ.
- СУИС-ийн захирлын 2012 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн А/137 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан журмын дагуу шинжлэх ухаан болон соёл, урлагийн салбарт гарамгай бүтээл туурвисан, язгуур урлаг, биет бус соёлыг өвлүүлэн үлдээх эрдмийн “шавь сургууль” үүсгэн буй болгоход дорвитой хувь нэмэр оруулсан, улс хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд болон хүн төрөлхтний тусын тулд оруулсан хувь нэмрийг харгалзан үзэж, СУИС-ийн “Хүндэт доктор”, “Хүндэт профессор” цол олгодог.

**Дүгнэлт:** Багшийн үнэлгээ оновчтой, тодорхой.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

#### **4.3 Багшийн хөгжил**

Багш нар мэргэжлийн болон багшлах ур чадвараа дээшлүүлэх, судалгаа шинжилгээ хийх, магистрын судалгаа удирдах ур чадвараа ахиулахад нь чиглэсэн үйл ажиллагааг системтэй хэрэгжүүлж, боловсролын үйлчилгээнд шинэ арга зүй, инноваци нэвтрүүлэхийг дэмжин урамшуулдаг байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Багшийн хөгжлийн бодлого, хөтөлбөрийн хүрээнд Соёл, урлагийн их сургуулийн 2012 оны Эрдмийн зөвлөлөөр хэлэлцэн баталсан СУИС-ийг 2012-2021 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө, 2017 оны Удирдах зөвлөлийн тогтоолоор баталсан СУИС-ийг 2018-2024 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө түүнд нийцүүлэн гаргасан дүрэм журмууд, 2011 оны 12 дугаар сарын 27-ны А/318 тоот тушаалаар баталсан Багшийн хөгжил хөтөлбөр, 2018 оны 10 дугаар сарын 23-ны Эрдмийн зөвлөлийн тогтоолоор сайшаасан Багшийн хөгжил хөтөлбөр /2018-2024/
- Багш нарын компьютер, гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор 2015, 2017, 2020 онд тэдний компьютерын болон англи хэлний түвшин тогтоох шалгалтыг авч “JET”, “RAFFLES” гадаад хэлний төвүүдэд сургалтад хамруулсан.
- Соёл судлалын тэнхмийн 4 багш соёл судлалын ухааны докторын зэрэг хамгаалж, 2 багш докторантын сургалтаа дуусгаж диссертаци бичих ажилдаа орсон.

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

- Жил бүр багш нарын дунд спортын уралдаан тэмцээн зохион байгуулдаг ба жил бүр багш нарыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, багш, тэнхмийн эрхлэгчдэд 7 хоногийн 1 өдрийг бие даалт болгон эрдмийн ажил хийхэд нь дэмжлэг үзүүлдэг.
- Ж.Мяндас АНУ-д музей судлалын чиглэлээр мэргэжил дээшлүүлсэн, Б.Мөнхбадрал Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас зохион байгуулсан “Аялал жуулчлал төлөвлөлт” сургалтад хамрагдаж, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Алшаа аймагт судалгааны багийн гишүүнээр ажиллажээ.
- Багш Э.Энхсайхан 2016-2017 оны хичээлийн жилд багшлах эрхийн сертификат олгох сургалтад хамрагдаж сертификат авсан. CDIО цуврал сургалтад нийт багш нар оролцон сертификат авч сургалтын хөтөлбөр боловсруулалтын мэдлэгээ дээшлүүлсэн ба ОХУ-ын Москва хотод Хотын соёлыг ойлгох нь сургалтад хамрагдсан. Энэ хугацаанд 2 удаа багш нарын аттестатчилал явуулахад 2017-2018 оны хичээлийн жилд тэнхмийн 5 багш албан тушаалын шат ахисан. 2019-2020 оны хичээлийн жилд Ч.Мөнхжаргал, М.Ганжаргал, Б.Мөнхбадрал нар шатлал ахисан байна.

**Дүгнэлт:** Сургуулийн удирдлагаас багш нарынхаа хөгжил, дэвшилд анхаарч, зохих эрх зүйн орчинг бүрдүүлж ирсний үр дүнд ажил ахицтай хэрэгжиж ирсэн.

**Үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **4.4 Судалгаа ба хөгжил**

Багш нар хөтөлбөрийн судлагдахуунтай холбоотой судалгааны ажлыг идэвхтэй хийдэг, шаардлагатай тохиолдолд судалгааны баг бүрдүүлж, магистрантуудыг судалгаанд татан оролцуулдаг байна. Үүний зэрэгцээ үндэсний болон олон улсын эрдэмтдийн баг, сүлжээ, мэргэжлийн байгууллагын идэвхтэй гишүүн байхыг сургуулийн зүгээс дэмждэг байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

